МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 11 өдөр Дугаар А/168 Мөрөн сум

Хогийн цэгийг үе шаттайгаар сайжруулах /Мөрөн сум/ арга хэмжээний жагсаалт, төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдана авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Хогийн цэгийг үе шаттайгаар сайжруулах (Мөрөн сум)” арга хэмжээний ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д үүрэг болгосугай.

3.“Мөрөн сумын хогийн цэгийг үе шаттайгаар сайжруулах” худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010525

Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дугаар
сарын 11-ний өдрийн А/168 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНЫ ТӨСВИЙН ЖИЛД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайг хумих, тархалтыг бууруулах, нэг цэгээр гарц гаргах /Мөрөн сум/		100,000,000
2	Бульдозер худалдан авах	1	200,000,000
Нийт дүн			300,000,000